

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН  
САНААЧИЛГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 19 ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын Үндэсний зөвлөлийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:** Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын (ОУИТБС) Ажлын албаны 2020 оны төлөвлөгөөний биелэлт, 2021 оны төлөвлөгөөний төсөл, 2019 оны нэгтгэл тайлангийн төслийг Үндэсний зөвлөлийн гишүүдэд цахимаар хүргүүлж, эчнээ танилцуулав.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:** Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 19 дүгээр хуралдаанаас дараах шийдвэрүүдийг гаргахаар тогтов:

1. Ажлын албаны 2020 оны төлөвлөгөөний биелэлтэй танилцаж, 2021 оны төлөвлөгөөний төсөлд Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг тусган батлах;

2. Хараат бус хянагч-нэгтгэгч "Грант Торонто Аудит" ХХК-ийн боловсруулсан 2019 оны нэгтгэл тайлангийн төсөлд Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг тусгасны үндсэн дээр хүлээн авах;

3. Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд: Дараах арга хэмжээг авахыг даалгав.

3.1. 2019 оны нэгтгэл тайланд тусгагдсан санал, зөвлөмжүүдийг 2021 оны ажлын төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтийг зохион байгуулах;


3.2. 2019 оны нэгтгэл тайланг Ажлын албаны цахим сүлжээнд байршуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэх;

3.3. 2019 оны нэгтгэл тайлангийн англи хэл дээрх хувилбарыг ОУИТБС-ын Олон Улсын Удирдах хороонд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүргүүлэх;

3.4. 2019 оны нэгтгэл тайлангийн хараат бус хянагч-нэгтгэгч компанийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд ажилласан "Захиргааны шинэ санаачилга" ТББ-ын тэргүүн С.Цэрэнпүрэв, "Монголын Байгаль орчны иргэний зөвлөл"-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд нарт тус бүр 135,000 төгрөгийн урамшууллыг холбогдох журмын дагуу олгох ажлыг зохион байгуулах.

*Тангилга:*

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД  
МОНГОЛЫН ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ



Г.НАНДИНЖАРГАЛ